



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/256

Номгон


Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлж, хөдөлгөөний хязгаарлалтын
дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/236 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 37 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдварын тархалт Улаанбаатар хотод өсөн нэмэгдэж тус аймагт халдвар зөөвөрлөгдөн орж ирж батлагдсан тохиолдлуудыг нэмэгдүүлэх эрсдэл өндөр байгаа тул халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж, гэрийн тусгаарлалт, ажиглалт болон төвлөрсөн суурин газруудруу нэвтрэх хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгаж иргэд, олон нийтийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 00:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 24.00 цаг хүртэл гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, аймгийн хэмжээнд явган хүн болон авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зогсоосугай.

2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоон, явган хүн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зогсоосонтой холбогдуулан үйл ажиллагаа явуулах байгууллага, аж ахуй нэгжүүдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН
621010645